

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	13
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал.....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	17
Залруулсан алдаа	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	19
4. Менежментийн захидал	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	24



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Д.ЗОРИГТ ТАНАА

2021.02.25 № 07/520
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчаас Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 22 зорилтын 83 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаснаас коронавирус халдварын цар тахлын улмаас 3 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Үүнд: Нийгмийн даатгалын шинэчлэлийн асуудал болон багц хуулийн төслийн зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг, “Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтооход анхаарах асуудлууд” сэдэвт сургалт зохион байгуулах, Төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын хүрээнд Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг шалгах арга хэмжээнүүд тус тус хэрэгжээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Аудитаар илрүүлсэн батлагдсан орон тооны хязгаарыг баримталж ажиллаагүй, цалингийн нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгоогүй зэрэг нийт 464,859.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 30,989.2 мянган төгрөгөөс давсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.9, Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 51 дүгээр зүйлийн 51.1, 51.1.4, 57 дугаар зүйлийн 57.2.4-т заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	147,549,189.26	103,695,716.65
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	80,451,367.24	51,791,224.64
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	80,451,367.24	51,791,224.64
31210	Төгрөг	80,451,367.24	51,791,224.64
31211	Төрийн сангийн харилцах	80,451,367.24	6,004,107.15
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	45,787,117.49
33	АВЛАГА	1,674,470.00	714,470.00
33500	Бусад авлага	1,674,470.00	714,470.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,674,470.00	714,470.00
35	БАРАА МАТЕРИАЛ	65,423,352.02	51,190,022.01
35400	Хангамжийн материал	65,423,352.02	51,190,022.01
35410	Бичиг хэргийн материал	0.00	6,335,169.99
35420	Аж ахуйн материал	0.00	41,704,825.02
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	3,150,027.00
35470	Бусад хангамжийн материал	65,423,352.02	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,662,458,664.24	5,424,964,333.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,662,458,664.24	5,424,964,333.36
39200	Биет хөрөнгө	5,469,301,087.84	5,241,508,173.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,053,156,270.23	5,053,156,270.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	-88,660,263.95	-175,340,527.89
39203	Авто-тээврийн хэрэгсэл	447,180,000.00	447,180,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-382,445,461.51	428,267,128.17
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	949,103,758.90	941,262,011.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	-680,764,490.67	-726,960,198.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	402,682,568.63	366,400,725.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	-230,951,293.79	-235,922,979.59
39300	Биет бус хөрөнгө	193,157,576.40	183,456,159.80
39301	Программ хангамж	65,845,386.00	49,695,386.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-34,602,234.60	-28,153,651.20
39303	Бусад биет бус хөрөнгө	134,783,039.00	134,783,039.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-32,676,034.00	-32,676,034.00
39305	Бусад биет бус хөрөнгө газар	59,807,420.00	59,807,420.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,810,007,853.50	5,528,660,050.01
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,079,202.41	860,120.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,079,202.41	860,120.00
41300	Өглөг	11,079,202.41	860,120.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	9,797,402.41	686,310.00
41360	Бусад өглөг	1,281,800.00	173,810.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,281,800.00	173,810.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,798,928,651.09	5,527,799,930.01
51	Засгийн газрын хувь оролцоо	5,798,928,651.09	5,527,799,930.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,130,919,957.98	2,130,919,957.98
51100	Өмч: - төрийн	2,130,919,957.98	2,130,919,957.98
51200	Хуримтлагдсан үр дүн	1,980,381,901.39	1,709,253,180.31
51210	Өмнөх үеийн үр дүн	2,183,139,288.03	1,981,331,891.38
51220	Тайлант үеийн үр дүн	-202,757,386.64	-272,078,711.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,687,626,791.72	1,687,626,791.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,810,007,853.50	5,528,660,050.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,079,864,679.10	2,806,391,531.54
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	426,767,989.35	185,251,452.00
120	Нийтлэг татварын бус орлого	426,767,989.35	185,251,452.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	426,767,989.35	185,251,452.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	426,767,989.35	185,251,452.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,653,096,689.75	2,621,140,079.54
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	298,031,160.54	43,150,485.40
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	298,031,160.54	8,550,485.40
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	34,600,000.00
1330	Төсвийн захирагчаас	0.00	147,469,494.14
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	147,469,494.14
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,355,065,529.21	2,430,520,100.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,355,065,529.21	1,330,520,100.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.00	1,100,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,280,629,622.57	3,068,208,661.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,280,629,622.57	3,068,208,661.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,879,943,175.86	2,693,289,297.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,404,054,313.54	1,627,593,715.34
210101	Үндсэн цалин	1,131,328,854.54	1,234,537,523.34
210102	Нэмэгдэл	272,725,459.00	393,056,192.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,560,045.31	213,507,343.43
210201	Тэтгэврийн даатгал	113,503,494.33	142,921,815.69
210202	Тэтгэмжийн даатгал	14,022,615.75	17,657,057.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,207,918.99	14,112,835.40
210204	Ажилгүйдлийн даатгал	2,797,740.75	3,522,871.17
210205	Эрүүл мэндийн даатгал	28,028,275.49	35,292,763.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,060,620.00	29,979,264.44
210301	Гэрэл, цахилгаан	23,064,520.00	17,892,083.95
210302	Түлш, халаалт	15,217,800.00	8,805,303.73
210303	Цэвэр, бохир ус	9,778,300.00	3,281,876.76
2104	Хангамж, бараа материалын зардал	266,172,975.36	121,986,579.58
210401	Бичиг хэрэг	33,615,199.46	28,029,230.00
210402	Тээвэр, шатахуун	11,968,385.00	21,208,667.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,964,203.00	23,917,959.59
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	981,600.00	450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,135,607.90	36,932,862.99
210407	Аж ахуйн материал худалдан авсан зардал	150,507,980.00	0.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	11,447,860.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,376,065.00	36,259,398.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,550,300.00	18,815,248.00
210604	Урсгал засвар	17,825,765.00	17,444,150.00
2107	Томилолт, зочны зардал	81,136,500.00	52,513,198.00
210702	Дотоод томилолтын зардал	81,136,500.00	27,213,540.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	25,299,658.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	283,097,987.46	251,292,428.01

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,469,716.00	246,095,386.01
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	6,945,000.00	3,144,688.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	990,000.00	373,004.00
210807	Газрын төлбөр	4,685,300.00	1,518,650.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,648,500.00	160,700.00
210813	Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс	4,950,000.00	0.00
210817	Эмнэлэг, хөдөлмөрийн магадлалын зардал	152,993,471.46	0.00
210818	Гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	52,416,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	605,484,669.19	360,157,370.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	260,900,780.00	48,521,514.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	344,583,889.19	311,635,856.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	400,686,446.71	374,919,364.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	151,256,075.00	160,055,072.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	10,046,600.00	0.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,063,916.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,586,599.00	98,764,953.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	115,558,960.00	61,290,119.00
2135	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	249,430,371.71	214,864,292.58
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	249,430,371.71	47,141,576.78
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг – бусад	0.00	69,938,756.80
213504	Төвлөрүүлэх шилжүүлэг - хөрөнгийн	0.00	97,783,959.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-200,764,943.47	-261,817,130.24
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	3,937,500.00	0.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	3,937,500.00	0.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	14,846,416.67	10,261,580.83
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	14,846,416.67	10,261,580.83
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-211,673,860.14	-272,078,711.07

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,721,486,185.24	2,767,124,587.20
120	Нийтлэг татварын бус орлого	1,068,389,495.49	237,119,137.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	214,160,631.35	185,251,452.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	214,160,631.35	185,251,452.00
120009	Бусад орлого	854,228,864.14	51,867,685.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,653,096,689.75	2,530,005,450.20
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	298,031,160.54	43,150,485.40
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	298,031,160.54	8,550,485.40
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	34,600,000.00
1330	Төсвийн захирагчдаас	0.00	56,334,864.80
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	56,334,864.80
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,355,065,529.21	2,430,520,100.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,255,065,529.21	1,330,520,100.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,100,000,000.00	1,100,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,763,700,207.49	2,795,784,729.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,763,700,207.49	2,795,784,729.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,363,013,760.78	2,518,649,324.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,408,268,932.18	1,636,950,512.98
210101	Үндсэн цалин	1,118,005,846.44	1,144,866,196.17
210102	Нэмэгдэл	290,263,085.74	492,084,316.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	177,786,784.00	213,261,638.20
210201	Тэтгэврийн даатгал	119,010,473.20	149,414,435.55
210202	Тэтгэмжийн даатгал	14,702,967.04	16,181,516.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,751,706.42	12,847,993.67
210204	Ажилгүйдлийн даатгал	2,933,481.94	3,165,053.73
210205	Эрүүл мэндийн даатгал	29,388,155.40	31,652,638.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,060,620.00	29,979,264.44
210301	Гэрэл, цахилгаан	23,064,520.00	17,892,083.95
210302	Түлш, халаалт	15,217,800.00	8,805,303.73
210303	Цэвэр, бохир ус	9,778,300.00	3,281,876.76
2104	Хангамж, бараа материалын зардал	106,183,548.00	106,776,216.59
210401	Бичиг хэрэг	33,176,068.00	27,117,390.00
210402	Тээвэр, шатахуун	11,968,385.00	21,208,667.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,964,203.00	23,917,959.59
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчийн устгал, ариутгал	981,600.00	450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,093,292.00	34,082,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,349,745.00	39,193,867.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,523,980.00	21,749,717.00
210604	Урсгал засвар	17,825,765.00	17,444,150.00
2107	Томилолт, зочны зардал	81,136,500.00	52,513,197.98
210702	Дотоод томилолтын зардал	81,136,500.00	27,213,540.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах зардал	0.00	25,299,657.98

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,236,326,851.60	391,453,113.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	246,095,386.01
210803	Даатгалын үйлчилгээ	6,945,000.00	3,144,688.00
	Мэдээлэл, сурталчилгааны зардал	58,469,716.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	990,000.00	373,004.00
210807	Газрын төлбөр	4,685,300.00	1,518,650.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,648,500.00	160,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	953,228,864.14	89,095,000.00
210813	Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс	4,950,000.00	0.00
210817	Эмнэлэг, хөдөлмөрийн магадлалын зардал	152,993,471.46	0.00
210818	Бусад мөнгөн зарлага	52,416,000.00	51,065,685.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	260,900,780.00	48,521,514.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	260,900,780.00	48,521,514.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	400,686,446.71	277,135,405.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	151,256,075.00	160,055,072.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	10,046,600.00	0.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,063,916.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,586,599.00	98,764,953.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	115,558,960.00	61,290,119.00
2135	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	249,430,371.71	117,080,333.58
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	249,430,371.71	47,141,576.78
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг - бусад	0.00	69,938,756.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-42,214,022.25	-28,660,142.58
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-42,214,022.25	-28,660,142.58
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	122,665,389.49	80,451,367.24
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	80,451,367.24	51,791,224.66

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,130,919,957.98	1,687,626,791.72	2,214,899,143.05	6,033,445,892.75
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,130,919,957.98	1,687,626,791.72	2,214,899,143.05	6,033,445,892.75
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-234,517,241.67	-234,517,241.67
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,130,919,957.98	1,687,626,791.72	1,980,381,901.38	5,798,928,651.08
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	949,990.00	949,990.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,130,919,957.98	1,687,626,791.72	1,981,331,891.38	5,799,878,641.08
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-272,078,711.07	-272,078,711.07
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,130,919,957.98	1,687,626,791.72	1,709,253,180.31	5,527,799,930.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Данс код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		80,451,367.24		
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,600,520,100.00	2,555,986,083.22	44,813,116.78	98.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,600,520,100.00	2,555,986,083.22	44,813,116.78	98.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,466,614,600.00	2,422,756,011.22	43,858,588.78	98.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,637,430,700.00	1,636,950,512.98	480,187.02	100.0
210101	Үндсэн цалин	1,107,571,500.00	1,144,866,196.17	-37,294,696.17	103.4
210102	Нэмэгдэл	416,757,200.00	381,122,983.74	35,634,216.26	91.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	113,102,000.00	110,961,333.07	2,140,666.93	98.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	221,478,900.00	213,261,638.20	8,217,261.80	96.3
210201	Тэтгэврийн даатгал	159,581,700.00	149,414,435.55	10,167,264.45	93.6
210202	Тэтгэмжийн даатгал	15,474,300.00	16,181,516.77	-707,216.77	104.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,379,400.00	12,847,993.67	-468,593.67	103.8
210204	Ажилгүйдлийн даатгал	3,094,900.00	3,165,053.73	-70,153.73	102.3
210205	Эрүүл мэндийн даатгал	30,948,600.00	31,652,638.48	-704,038.48	102.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,864,900.00	29,979,264.44	6,885,635.56	81.3
210301	Гэрэл, цахилгаан	19,112,000.00	17,892,083.95	1,219,916.05	93.6
210302	Түлш, халаалт	12,474,600.00	8,805,303.73	3,669,296.27	70.6
210303	Цэвэр, бохир ус	5,278,300.00	3,281,876.76	1,996,423.24	62.2
2104	Хангамж, бараа материалын зардал	106,512,800.00	105,826,226.59	686,573.41	99.4
210401	Бичиг хэрэг	27,117,400.00	26,167,400.00	950,000.00	96.5
210402	Тээвэр, шатахуун	21,375,100.00	21,208,667.00	166,433.00	99.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	23,079,200.00	23,917,959.59	-838,759.59	103.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	858,900.00	450,000.00	408,900.00	52.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	34,082,200.00	34,082,200.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,194,300.00	39,193,867.00	433.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,750,100.00	21,749,717.00	383.00	100.0
210604	Урсгал засвар	17,444,200.00	17,444,150.00	50.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	31,500,000.00	27,213,540.00	4,286,460.00	86.4
210702	Дотоод албан томилолт	31,500,000.00	27,213,540.00	4,286,460.00	86.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	348,025,800.00	324,763,428.01	23,262,371.99	93.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	245,156,400.00	230,471,386.01	14,685,013.99	94.0
210803	Даатгалын үйлчилгээ	6,945,000.00	3,144,688.00	3,800,312.00	45.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	990,000.00	373,004.00	616,996.00	37.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	456,900.00	0.00	456,900.00	-
210807	Газрын төлбөр	4,685,300.00	1,518,650.00	3,166,650.00	32.4
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	692,200.00	160,700.00	531,500.00	23.2
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	89,100,000.00	89,095,000.00	5,000.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,607,200.00	45,567,534.00	39,666.00	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	45,607,200.00	45,567,534.00	39,666.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	133,905,500.00	133,230,072.00	675,428.00	99.5

2132	Бусад урсгал шилжүүлэг	133,905,500.00	133,230,072.00	675,428.00	99.5
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	279,100.00	0.00	279,100.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	99,142,000.00	98,764,953.00	377,047.00	99.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,484,400.00	34,465,119.00	19,281.00	99.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,600,520,100.00	2,499,651,218.42	100,868,881.58	96.1
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,430,520,100.00	2,384,338,523.22	46,181,576.78	98.1
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,330,520,100.00	1,284,338,523.22	46,181,576.78	96.5
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,100,000,000.00	1,100,000,000.00	0.00	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	170,000,000.00	115,312,695.20	54,687,304.80	67.8
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	170,000,000.00	115,312,695.20	54,687,304.80	67.8
	Тохируулгын өөрчлөлт		-27,674,722.22		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		51,791,224.64		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	89	89	-	
620001	Удирдах ажилтан	10	10	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	79	79	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)		19,685,970.00
УРСГАЛ ЗАРДАЛ		19,685,970.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		19,685,970.00
Хангамж, бараа материалын зардал		949,990.00
Бичиг хэрэг		949,990.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		15,782,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		15,624,000.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		158,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		2,953,980.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,953,980.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		43,150,485.40
Нэмэлт санхүүжилтийн орлого		43,150,485.40
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		8,550,485.40
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		34,600,000.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Д.Зоригт танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгадагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгадагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, бүртгэлийг сайжруулах, бүтэц орон тооны хязгаарыг баримталж ажиллах, авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулж байх, санхүү, татвар, нийгмийн даатгалын тайланг хуулиар тогтоосон хугацаанд бүрэн тайлагнаж хүргүүлэх, анхан шатны баримт бүрдлийг хангаж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 23-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор П.Чанцалдулам, аудитор Ц.Энхжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/86 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Нийгмийн даатгалын ерөнхий газрын эрхэм зорилго нь даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэхэд оршино. Нийгмийн даатгалын ерөнхий газрын үндсэн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах,
- Нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах, нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах,
- Нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх,
- Доод шатны байгууллагынхаа үйл ажиллагаанд хяналт тавих, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэхээр заажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2009 оны 396 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн өөрчлөлтийг оруулаагүй байна.

Тайлант онд Дотоод аудит, мониторингийн газар нь нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2020 оны А/57 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын байгууллагуудын автомашин ашиглалтын журмын хэрэгжилтэд дотоод аудит хийжээ. Аудитаар Нийгмийн даатгалын ерөнхий газар нь жолоочтой “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ” байгуулаагүй, автомашины хувийн хэргийг бүрэн хөтлөөгүй, шатахуун зарцуулалтын тооцоонд автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг улирлын нөхцөлөөр нэмэгдүүлж, бууруулж тооцоогүй зөрчил илрүүлсэн байна.

Дотоод аудитаар ахлах нягтлан бодогч эд хөрөнгө хариуцсан ажилтныг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах, автомашин шатахуун зарцуулалтын нормыг тогтоож, шатахуун зарцуулалтын улирлын өөрчлөлтүүдийг нарийвчлан үнэн зөв тооцож, шатахууны хэмнэлт, хэтрэлтийн тооцоог хийж хэвших зөвлөмжийг өгсөн байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,098,923.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 30,989.2 мянган төгрөгөөр тооцсон. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 281,347.9 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
	1	2	3=2-1
Б			
Мөнгөн хөрөнгө	80,451.4	51,791.2	-28,660.2
Авлага	1,674.5	714.5	-960.0
Бараа материал	65,423.4	51,190.0	-14,233.4
Үндсэн хөрөнгө	5,662,458.6	5,424,964.3	-237,494.3
Нийт хөрөнгө	5,810,007.9	5,528,660.0	-281,347.9
Өр төлбөр	11,079.2	860.1	-10,219.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,798,928.7	5,527,799.9	-271,128.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,810,007.9	5,528,660.0	-281,347.9

Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 51,791.2 мянган төгрөг болж, 28,660.2 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангаас арга хэмжээний зардлыг санхүүжүүлснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 14,233.4 мянган төгрөгөөр буурсан нь бичиг хэрэг, аж ахуй, сэлбэг хэрэгслийн материалыг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,424,964.3 мянган төгрөг болж, 237,494.3 мянган төгрөгөөр буурчээ. Тус байгууллага нь үнэ төлбөргүйгээр 84,403.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж авч, 16,661.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил шилжүүлж, 128,014.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна. Тайлант хугацаанд 177,221.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь үндсэн хөрөнгө дансны дүн буурахад голлон нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 860.1 мянган төгрөг болж, 10,219.1 мянган төгрөгөөр буурсан нь ажиллагсдын цалингийн өглөг буурсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл буурсан нь тайлант онд санхүүгийн үр дүн 272,078.7 мянган төгрөгөөр буурч, өмнөх үеийн үр дүнд 949.9 мянган төгрөгийн залруулга хийснээс шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Төсвийн захирагч нь 2020 оны төсвийн төслийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,163,071.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь нийт зарлагыг 1,337,997.5 мянган төгрөгөөр бууруулж 2,825,074.1 мянган төгрөгөөр баталжээ. Төсвийн төслөөс шинээр сургалтын төв байгуулах зардлыг 583,117.2 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийн зардлыг 445,000.0 мянга, эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын зардлыг 162,667.8 мянга, гадаад томилолтын зардлыг 108,380.0 мянга, үр дүнгийн урамшууллыг 122,150.0 мянган төгрөгөөр бууруулан баталсан нь зардал буурахад нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд коронавирус цар тахалтай холбоотойгоор нэмэлт өөрчлөлт орсон байна. Нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны батлагдсан төсвийг 224,554.0 мянган төгрөгөөр бууруулж, 2,600,520.1 мянган төгрөгөөр баталжээ. Тухайлбал, Хичээл үйлдвэрлэлийн зардлыг 124,564.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 65,649.4 мянга, томилолтын зардлыг 53,445.2 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталжээ.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны зардалд 2,600,520.1 мянган төгрөг батлагдсанаас 1,330,520.1 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангаас, 1,100,000.0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 170,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангийн төсвөөс 1,330,520.1 мянга, эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс 1,100,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоос 172,607.6 мянга, нийт 2,603,127.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,555,986.1 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 47,141.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардал 2,555,986.1 мянган төгрөг буюу 98.3 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь эмнэлэг хөдөлмөрийн төв комисс, гомдлын шаардлагын зөвлөлийн батлагдсан төсвийг 13,863.3 мянган төгрөгөөр хэмнэснээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 23,262.4 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 8,217.3 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 6,885.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь голлон нөлөөлсөн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд хандив тусламжаар 8,550.5 мянга, гадаад төсөл хөтөлбөрөөс 34,600.0 мянга, нийт 43,150.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 15,782.0 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийхэд 2,954.0 мянга, бусад зардалд 950.0 мянга, нийт 19,686.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх 199 мэдээллээс 117 мэдээллийг хугацаандаа оруулж, 82 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 79,264.3 мянган төгрөгийн 7 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 485,312.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс, 20,453.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 13,358.9 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 451,500.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон тайлагналын алдаатай 20,453.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг залруулж, санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 464,859.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илрүүлснээс 13,358.9 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Тайлант онд хөлсөөр ажиллуулж байгаа 17 ажилтанд үр дүнгийн урамшууллыг 80.0 хувиар тооцон 10,600.5 мянган төгрөг, 5 ажилтанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг үндсэн цалингийн 5-20 хувиар тооцон 2,758.4 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-т "Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна", 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу олгоогүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 199 мэдээлэл мэдээлэхээс 2,351,733.6 мянган төгрөгийн 82 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Үүнд:

- Төсөв гүйцэтгэлийн талаар 2,202,267.6 мянган төгрөгийн 33 мэдээлэл,
- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын талаар 149,466.0 мянган төгрөгийн 18 мэдээлэл,
- Бусад шийдвэр үйл ажиллагааны талаар 31 мэдээлэл тус тус байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.7-д "Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг ... цахим хуудсанд байрлуулсан тухай бүр шинэчилж мэдээлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүүгийн бүртгэлд 2006 оноос ашиглаж байгаа "Sanhuu" программ хангамж нь нягтлан бодох бүртгэл хөтлөх программ хангамжийн зөвшөөрөл аваагүй, холбогдох хууль тогтоомж болон Сангийн сайдын баталсан заавар журмын дагуу тайлан мэдээ бэлтгэн боловсруулдаггүй байна. Тухайлбал,

- Санхүүгийн тайлан, тодруулгыг иж бүрэн бэлтгэдэггүй, ерөнхий дэвтрийн хураангуй бүртгэл, мөнгөн гүйлгээний журналыг боловсруулан гаргадаггүй, боловсруулалтыг автоматаар хийдэггүй,
- Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэл, цалингийн нэмэлт тооцооллыг дэлгэрэнгүй хялбар байдлаар харах боломжгүй,
- Ерөнхий журналд зарим гүйлгээ давхардаж бүртгэгдсэн,
- Санхүүгийн программд тохируулга хийхэд өмнөх тайлант хугацааны тайлан, мэдээ, гүйлгээ, тооцоолол зөрдөг,
- Санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар биш зэрэг алдаа гарч байна.

Энэ зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11-т "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийг нийтэд мэдээлэх", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ын холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын санхүү бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн зөвшөөрөгдөөгүй программ хангамжаар хөтлөн явуулж байгаа зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлсэн.

4. Нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүүгийн тайланд Баянгол дүүргийн 18 дугаар хороонд байрлалтай 2000 онд ашиглалтад орсон 2,442.6 мянган төгрөгийн үнэ бүхий 2 граж, Баянгол дүүргийн 12 дугаар хороонд байрлалтай 1999 онд ашиглалтад орсон 1,890.0 мянган төгрөгийн үнэ бүхий 1 бетонон граж бүртгэлтэй байна.

Гражийн газрыг Баянгол дүүргийн засаг даргын 2014 оны захирамжаар хуулийн этгээд болон иргэнд эзэмшүүлсэн байна. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь гражийн ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн гэж үзэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт акталж данснаас хасах саналыг хүргүүлжээ.

Энэ зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т “Төрийн байгууллага, албан газар ... нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй; 1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Баянгол дүүрэгт байрлалтай 3 гражтай холбоотой асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх талаар албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын зөвлөмж

Аудитаар илрүүлсэн 451,500.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Нийгмийн даатгалын ерөнхий газрын биет бус хөрөнгөд дахин үнэлүүлсэн 41,512.7 мянган төгрөгийн үнэ бүхий 7048 м² газар бүртгэлтэй байна. Тус газрыг Сонгинохайрхан дүүргийн засаг даргын 2007 оны захирамжаар 5 жилийн хугацаатай эзэмшүүлжээ. Газрын гэрчилгээг 2012 оноос хойш сунгуулаагүй бөгөөд 2897 м² газар шүүхийн маргаантай байна.

Мөн ажил олгогчийн буруугаас ажлаас чөлөөлөгдсөн 5 ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговор 58,278.9 мянган төгрөгийг цалингийн зардлаас олгосон, албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад багтаагүй 3 албан тушаалтан автомашин ашиглаж байна.

Газар, автомашины хэрэглээтэй холбоотой асуудлыг дараагийн аудитаар, нөхөн олговортой холбоотой асуудлыг дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Бүтэц орон тоотой холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд цалин, орон тоотой холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Засгийн газрын 2017 оны 344 дүгээр тогтоолоор баталсан орон тооны хязгаарыг баримтлалгүйгээр үйлчилгээний 19 ажилтан ажиллуулж, 176,751.7 мянган төгрөгийг цалингийн зардлаас олгосон,
- Нийгмийн даатгалын төлөөлөгчийн орон тоог батлаагүйгээр 12 ажилтан ажиллуулж, 66,274.7 мянган төгрөгийн цалин хөлс олгосон,
- Үйлчилгээний 19 ажилтнаас 16 ажилтантай хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.9 "... байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох", Засгийн газрын 2017 оны 344 дүгээр "Агентлаг байгуулах тухай" тогтоолын 8-д "Засгийн газрын агентлагийн орон тооны хязгаар"-ын 16 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай Нийгмийн даатгалын ерөнхий газар 82" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл: Цалингийн сан буруу төлөвлөгдөх, цалингийн төсөв хүрэлцэхгүй байх, төсвөөс үргүй зардал гарах.

1.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газраас тогтоосон орон тооны хязгаарыг баримталж ажиллах, нийгмийн даатгалын төлөөлөгчийн орон тоог баталж мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Анхан шатны баримт бүрдэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад нийт ажил гүйлгээний 37.7 хувь буюу 362,810.8 мянган төгрөгийн гүйлгээг түүвэрлэн шалгахад дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, төлбөрийн баримтгүй 54,408.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн,
- Ахмадын сангаас зарцуулсан хүндэтгэлийн арга хэмжээний 16,575.0 мянган төгрөгийн ажил гүйлгээний анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, ажил гүйцэтгэх гэрээг дүгнээгүй,
- Гадаад улсад суралцах эсэх нь тодорхой бус ажлаас түр чөлөөлсөн 1 ажилтанд 3 сарын цалинтай тэнцэх 3,384.2 мянган төгрөгийн нөхөн олговор олгосон,
- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэргүйгээр автомашинд засвар үйлчилгээ хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2-т "зургаан сараас дээш хугацааны сургалтаар ... бэлтгэгдэх болсон" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2.2 Эрсдэл: Зардал баталгаажихгүй байх, төсвөөс үргүй зардал гарах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

2.3 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримт бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх, ажил гүйцэтгэх гэрээг дүгнэж ажиллах, өмч хамгаалах комиссын шийдвэрээр автомашинд засвар үйлчилгээг хийж байх.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн өглөгийн эхний үлдэгдэл 9,191.5 мянга, эцсийн үлдэгдэл 4,304.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн, 2020 оны жилийн эцсийн байдлаар 714.5 мянган төгрөгийн авлага, 614.4 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Эрсдэл: Авлага, өглөг баталгаажихгүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

3.3 Өгсөн зөвлөмж: Авлага, өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулж байх;

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4. Үндсэн хөрөнгө, бараа материалын данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Тайлант онд үндсэн хөрөнгө бараа материалтай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Лицензийн хугацаа дууссан 9,518.4 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 1 биет бус хөрөнгийг өмч хамгаалах комиссоор шийдвэрлүүлээгүй,
- Үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэлд зарим хөрөнгө, барааны нэр тодорхой бус,
- Санхүүгийн тайлангаарх бараа материалын эцсийн үлдэгдэл эд хөрөнгийн тооллогын бүртгэлийн дүнгээс 141.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн, тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Эрсдэл: Хөрөнгө дутагдах, биетээр оршихгүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, тооллого үр дүнгүй байх.

4.3 Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хуулиар тогтоосон хугацаанд чанартай хийж, тооллогын үр дүнг хэлэлцэж санхүүгийн тайланд тусгах, ашиглагдахгүй байгаа биет бус хөрөнгийг өмч хамгаалах комиссоор хэлэлцүүлж, шийдвэрлэх, хөрөнгийн нэршлийг тодорхой болгох.

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

5 Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт:

Олгохоор тооцсон цалин нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дүнгээс 5,950.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн,

Тайлант онд өмнөх онд дутуу тайлагнасан хувь хүний орлогын албан татварын тайлангийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 808,316.8 мянган төгрөгийг нөхөн тайлагнасан байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т "Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, ... заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын ... жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ", Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 3-т "Ажил олгогч нь тухайн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг дараа сарын 05-ны өдрийн дотор нийгмийн даатгалын байгууллагад ирүүлэх ..." гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, тохиолдсон байх, үнэн зөв байх, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, ажиллагсдын цалин хөлс баталгаажихгүй байх;

5.3 Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, хувь хүний орлогын албан татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд үнэн зөв, бүрэн тайлагнаж хүргүүлэх;

5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

6 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

6.1 Илрүүлэлт:

Тайлант онд тээвэр шатахууны зардалд 21,208.7 сая төгрөгийг зарцуулснаас 18,880.0 (89.0%) мянган төгрөгийн шатахуун зарцуулалтын тооцоог автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг баримтлан тооцоогүй байна.

Энэ нь Авто тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т "тээвэрлэлтийн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн техник ашиглалтын талаар нийтлэг мөрдөх дүрэм, журам, норм, нормативыг батлах, тэдгээрийн биелэлтийг хангуулах", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг баримталж ажиллаагүй байна.

6.2 Эрсдэл: Засгийн газрын тогтоол зөрчигдөх, төсвөөс үргүй зардал гарах;

6.3 Өгсөн зөвлөмж: Шатахуун зарцуулалтын тооцоог Засгийн газрын тогтоолоор баталсан автомашины шатахуун зарцуулалтын жишиг нормыг баримталж хийх;

6.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

7 Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

7.1 Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүүгийн тайланд нэгтгэгдсэн төв сан, маягтын зарцуулалтын 2020 оны санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй байна. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын аппаратын үйл ажиллагааны зардлаас 89,095.0 мянган төгрөгийн улсын мэдээллийн маягт хэвлүүлэн бараа материалын дансанд бүртгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т "төсвийн шууд захирагч ... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа энэ хуулиар тогтоосон хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй", 9.4-д "Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8

дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайланг тайлагнаж, тушаана" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

7.2 Эрсдэл: Тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан баталгаажихгүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

7.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг бүрэн гүйцэд нэгтгэн тайлагнаж, хуулиар тогтоосон хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх;

7.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			САГ-2021/163/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Нийгмийн даатгалын ерөнхий газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хөлсөөр ажиллуулж байгаа 17 ажилтанд үр дүнгийн урамшууллыг 80 хувиар тооцон 10,600.5 мянган төгрөг, 5 ажилтанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг үндсэн цалингийн 5-20 хувиар тооцон 2,758.4 мянган төгрөгийг тус тус олгосон.	13,358.9	Албан шаардлага тогтоох	Тамгын газрын дарга	Б.Батсүх
2	Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 199 мэдээлэл мэдээлэхээс 82 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	-	Албан шаардлага тогтоох	Дотоод аудит мониторингийн газрын дарга	Б.Ганхуяг
3	Нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүүгийн бүртгэлд 2006 оноос ашиглаж байгаа "Sanhuu" программ хангамж нь нягтлан бодох бүртгэл хөтлөх программ хангамжийн зөвшөөрлийг аваагүй, холбогдох хууль тогтоомж болон Сангийн сайдын баталсан заавар журмын дагуу тайлан мэдээ бэлтгэн боловсруулдаггүй.	-	Албан шаардлага тогтоох	Мэдээлэл технологийн төвийн дарга	Г.Хүрэлбаатар
4	Нийгмийн даатгалын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3 гражийн газрыг Баянгол дүүргийн засаг даргын захирамжаар 2014 онд хуулийн этгээд, иргэнд эзэмшүүлсэн байна. Тус гражийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт акталж данснаас хасах саналыг хүргүүлсэн.	-	Албан шаардлага тогтоох	НДЕГ-ын өмч хамгаалах комиссын дарга	Г.Саран
5	Батлагдсан орон тооны хязгаарыг баримтлалгүйгээр үйлчилгээний 19 ажилтан ажиллуулж 176,751.7 мянган төгрөгийг цалингийн зардлаас олгосон, Нийгмийн даатгалын төлөөлөгчийн орон тоог батлаагүйгээр 12 ажилтан ажиллуулж 66,274.7 мянган төгрөгийн цалин хөлс олгосон.	243,026.4	Зөвлөмж өгөх	Тамгын газрын дарга	Б.Батсүх
6	Анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, төлбөрийн баримтгүй 74,368.1 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн,	74,368.1	Зөвлөмж өгөх	Дарга, Ахлах нягтлан бодогч	Д.Зоригт П.Адъяасүрэн
7	Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн өглөгийн эхний үлдэгдэл 9,191.5 мянга, эцсийн үлдэгдэл 4,304.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн, жилийн эцсийн байдлаар 714.5 мянган төгрөгийн авлага, 614.4 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.	10,520.4	Зөвлөмж өгөх	Дарга, Ахлах нягтлан бодогч	Д.Зоригт П.Адъяасүрэн

**Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

8	Лицензийн хугацаа дууссан 9,518.4 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 1 биет бус хөрөнгө ашиглалтгүй байгаа, Үндсэн хөрөнгө, бараа материалын зарим нэршил тодорхой бус, Санхүүгийн тайлангаарх бараа материалын эцсийн үлдэгдэл эд хөрөнгийн тооллогын бүртгэлийн дүнгээс 141.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.	9,659.9	Зөвлөмж өгөх	Дарга, Ахлах нягтлан бодогч	Д.Зоригт П.Адъяасүрэн
9	Олгохоор тооцсон цалин нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дүнгээс 5,950.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн, Тайлант онд өмнөх онд дутуу тайлагнасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг нөхөн тайлагнасан.	5,950.4	Зөвлөмж өгөх	Дарга, Ахлах нягтлан бодогч	Д.Зоригт П.Адъяасүрэн
10	Тайлант онд 18,880.0 (89.0%) мянган төгрөгийн шатахуун зарцуулалтын тооцоог автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг баримтлан тооцоогүй.	18,880.0	Зөвлөмж өгөх	Дарга, Ахлах нягтлан бодогч	Д.Зоригт П.Адъяасүрэн
11	Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны санхүүгийн тайланд нэгтгэгддэг төв сан, маягтын зарцуулалтын 2020 оны санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй. Тайлант онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын аппаратын үйл ажиллагааны зардлаас 89,095.0 мянган төгрөгийн улсын мэдээллийн маягт хэвлүүлэн бараа материалын дансанд бүртгээгүй.	89,095.0	Зөвлөмж өгөх	Санхүү бүртгэлийн газрын дарга	Б.Даваахүү
ДҮН		464,859.1			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 113/ОН0080

Улаанбаатар хот

САГ-2021/163/СТД-ТШЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь хөлсөөр ажиллуулж байгаа 17 ажилтанд үр дүнгийн урамшууллыг 80 хувиар тооцон 10,600.5 мянган төгрөг, 5 ажилтанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг үндсэн цалингийн 5-20 хувиар тооцон 2,758.4 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.9-д "... байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-т "... шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна", 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", 57 дугаар зүйлийн 57.2.4-т "үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон ... үр чадварын, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс тус тус бүрдэнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Хөлсөөр ажиллагсдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг холбогдох хууль, тогтоомжийг баримтлаагүйгээр олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Зоригт, ахлах нягтлан бодогч П.Адъяасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ЭНХЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 114/0110080

Улаанбаатар хот

СЯГ- 2021/163/СТА-ТШЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 3,215,688.8 мянган төгрөгийн 199 мэдээлэл мэдээлэхээс 2,351,733.6 мянган төгрөгийн 82 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Үүнд:

- Төсөв гүйцэтгэлийн талаар 2,202,267.6 мянган төгрөгийн 33 мэдээлэл,
- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын талаар 149,466.0 мянган төгрөгийн 18 мэдээлэл,
- Бусад шийдвэр үйл ажиллагааны талаар 31 мэдээлэл тус тус байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.7-д "Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсанд байрлуулан тухай бүр шинэчилж мэдээлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Зоригт, ахлах нягтлан бодогч П.Адъяасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ЭНХЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 115/АДН0080

Улаанбаатар хот

САГ- 2021/163/СТД-1ЦЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүүгийн бүртгэлд 2006 оноос ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн "Sanhuu" програм хангамж нь нягтлан бодох бүртгэл хөтлөх програм хангамжийн зөвшөөрлийг аваагүй, холбогдох хууль тогтоомж болон Сангийн сайдын баталсан заавар журмын дагуу тайлан мэдээ бэлтгэн боловсруулдаггүй байна. Тухайлбал,

- Санхүүгийн тайлан, тодруулгыг иж бүрэн бэлтгэдэггүй, ерөнхий дэвтрийн хураангуй бүртгэл, мөнгөн гүйлгээний журналыг боловсруулан гаргадаггүй, боловсруулалтыг автоматаар хийдэггүй,
- Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэл, цалингийн нэмэлт тооцооллыг дэлгэрэнгүй хялбар байдлаар харах боломжгүй,
- Ерөнхий журналд зарим гүйлгээ давхардаж бүртгэгдсэн,
- Санхүүгийн програмд тохируулга хийхэд өмнөх тайлант хугацааны тайлан, мэдээ, гүйлгээ, тооцоолол зөрдөг,
- Санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар биш зэрэг алдаа гарч байна.

Энэ зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11-т "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн програм хангамжийг нийтэд мэдээлэх", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн програмд тавигдах шаардлага"-ын холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын санхүү бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн зөвшөөрөгдөөгүй програм хангамжаар хөтлөн явуулж байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Зоригт, ахлах нягтлан бодогч П.Адъяасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ЭНХЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 46/ДОН0080

Улаанбаатар хот

САГ-2021/163/СТА-ТШЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүүгийн тайланд Баянгол дүүргийн 18 дугаар хороонд байрлалтай 2000 онд ашиглалтад орсон 2,442.6 мянган төгрөгийн үнэ бүхий 2 граж, Баянгол дүүргийн 12 дугаар хороонд байрлалтай 1999 онд ашиглалтад орсон 1,890.0 мянган төгрөгийн үнэ бүхий 1 бетонон граж бүртгэлтэй байна.

Баянгол дүүргийн засаг даргын захирамжаар 2014 онд 2 гражийн газрыг Бүрд пропертиз ХХК-д, 1 гражийн газрыг 1 иргэнд эзэмшүүлсэн байна. Байгууллагын удирдлага гражийн ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн гэж үзэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2020 оны 1/274 дугаар албан бичгээр акталж данснаас хасах саналыг хүргүүлжээ.

Энэ зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй; 1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дахь хэсэгт "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даван гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А95 дугаар тушаалаар баталсан


“Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн
ШААРДАХ нь:

1. Баянгол дүүрэгт байрлалтай 3 гражтай холбоотой асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлж, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Зоригт, ахлах нягтлан бодогч П.Адъяасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ЭНХЖАРГАЛ

[illegible]

This image shows a full page of a document template designed for handwriting practice or general note-taking. It consists of approximately 28 evenly spaced horizontal dotted lines across the entire width of the page. The background is plain white, and there are no margins, headers, footers, or other markings present.

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.